



ШҮҮХИЙН СУРГАЛТ,
СУДАЛГАА,
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН

**ШҮҮХЭЭС ЭРҮҮГИЙН
ХЭРГИЙГ БУЦААХ ЭРХ
ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

СУДАЛГААНЫ САН: ЭХ/00/2022/08/25

ШҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТӨВ
2022.10.20

ТОВЬЁГ

УДИРТГАЛ

ҮНДСЭН ХЭСЭГ

1. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС
2. АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛС
3. БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛС
4. БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛС
5. БҮГД НАЙРАМДАХ ЛАТВИ УЛС
6. ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС
7. БҮГД НАЙРАМДАХ КАЗАКСТАН УЛС

ДҮГНЭЛТ

ЭХ СУРВАЛЖ

Хавсралт

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн нэгдсэн улс
АШШ	Анхан шатны шүүх
БНКУ	Бүгд Найрамдах Казахстан Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНЛУ	Бүгд Найрамдах Латви улс
ДЗШШ	Давж заалдах шатны шүүх
ОХУ	Оросын Холбооны Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХШШ	Хяналтын шатны шүүх

УДИРТГАЛ

Судалгааны зорилго:

Тус судалгааны зорилго нь гадаадын зарим улс оронд дээд шатны шүүхээс эрүүгийн хэргийг доод шатны шүүх, прокурорын газарт буцаах үндэслэлийг судлах түүнчлэн хяналтын шат, давж заалдах шатны шүүх өмнөх шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж эцэслэн шийдвэрлэх эрх хэмжээг харьцуулан судлахад оршино.

Судалгааны хамрах хүрээ:

Энэхүү судалгаанд АНУ, БНКУ, БНХАУ, БНСУ, БНЛУ, ОХУ, ХБНГУ-ын шүүхийн эрх зүйн зохицуулалт, эрүүгийн процессын хууль тогтоомжийн хүрээнд харьцуулан судлав.

Судалгааны арга зүй:

Судалгааг гүйцэтгэхдээ эрх зүйн социологийн судалгааны аргууд болох задлан шинжилж, нэгтгэн дүгнэх (анализ, синтез), баримт бичигт шинжилгээ хийх, харьцуулалтын аргуудыг ашиглав.

Судалгааны бүтэц:

Тус судалгаа нь Удиртгал, Үндсэн хэсэг, Дүгнэлт, хавсралт хэсгээс бүрдэнэ.

ҮНДСЭН ХЭСЭГ

1.Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ-д давж заалдах ажиллагаа нь доод шатны шүүхийн алдааг засах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилготой. Эрүүгийн процесст давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үйл баримтын эсрэг “*Berufung*”, хууль хэрэглээний эсрэг “*Revision*”, шүүхийн бусад шийдвэрийн эсрэг “*Beschwerde*” гомдол гаргах ажиллагаа гэж гурван төрөлд хуваадаг.

“*Berufung*” давж заалдах гомдлыг зөвхөн орон нутгийн шүүхийн шийдвэрт гаргах боломжтой бөгөөд мужийн болон мужийн дээд шүүхээс хуулиар харьяалуулсан хэрэг маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэж гаргасан шийдвэрт явагдах боломжгүй байдаг.¹

(1) Орон нутгийн шүүхийн шийдвэрээр² тогтоосон хэргийн үйл баримт, шүүгдэгчийн гэм буруу, оногдуулсан ялтай холбогдуулан мужийн шүүхэд яллагдагч, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон прокурор давж заалдах гомдол /*application*/ гаргасан тохиолдолд “*Berufung*” ажиллагаагаар хэргийг хянан шийдвэрлэнэ. Энэ төрлийн давж заалдах ажиллагааг *re-trial* буюу хэргийг дахин хянан хэлэлцэх хэлбэр хэмээн нэрлэдэг ба зорилго нь доод шатны шүүхийн алдааг засахад оршино.³

ХБНГУ-д орон нутгийн шүүх буюу хамгийн доод шатны шүүхэд хөнгөн хэрэг маргааныг ихэвчлэн шүүгч дангаар хянан шийдвэрлэдэг ба алдаа гарах магадлал давж заалдах шатны шүүх /*Regional court*/-тэй харьцуулахад харьцангуй их байдаг учраас давж заалдах шатанд гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг хянан шийдвэрлэж алдааг залруулахыг зорьдог байна. Давж заалдах шүүх хуралдаанаар нотлох баримтуудыг дахин шинжлэн судлах, гэрч, шинжээчдийг дуудаж мэдүүлэг авах, анхан шатны шүүх хуралдааны тэмдэглэлийг сонсох, шинээр нотлох баримт шинжлэх боломжтой.⁴

Шүүх гомдлыг үндэслэлтэй гэж үзвэл анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож тогтоогдсон хэргийн үйл баримтад тулгуурлан шийдвэр гаргана. Өөрөөр хэлбэл, “*Berufung*” зарчмаар давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэж байгаа тохиолдолд шүүх шүүгдэгчийн гэм буруу болон хэргийн үйл баримтын талаар өөрийн дүгнэлтийг өгөх эрхтэй. Оногдуулсан ял шийтгэлийг эсэргүүцэж гомдол гаргасан бол ялыг өөрчлөх эрхтэй ч “*reformation in peius*” буюу өмнөх

¹ Micheal Bohnlander, Principles of German Criminal Procedure, US, 2012, p.251, <https://b-ok.asia/book/3656000/4e3da3> (Сүүлд үзсэн:2022.10.14).

² ХБНГУ-ын шүүх тогтолцооны талаар дараагийн хэсэгт дэлгэрүүлэн авч үзсэн.

³ Micheal Bohnlander, Principles of German Criminal Procedure, US., 2012, p.250, <https://b-ok.asia/book/3656000/4e3da3>. (Сүүлд үзсэн:2022.10.14).

⁴ German Code of Criminal Procedure (ХБНГУ-ын Эрүүгийн процессын хууль), 323.3 дугаар зүйл [German Code of Criminal Procedure \(Strafprozeßordnung – StPO\) \(gesetze-im-internet.de\)](https://www.gesetze-im-internet.de/strafprozeßordnung/index.html), (Сүүлд үзсэн:2022.10.14).

шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг хүндрүүлж оногдуулахгүй байх зарчмыг баримтална.⁵

(2) Доод шатны шүүхийн шийдвэрийн хууль хэрэглээний талаар гомдол гаргахыг “Revision” давж заалдах ажиллагаа гэнэ. Орон нутгийн шүүх, мужийн шүүхийн эсрэг гаргасан эл давж заалдах гомдлыг мужийн дээд шүүхээр хянан хэлэлцэх бол мужийн дээд шүүхийн эсрэг гаргасан гомдлыг холбооны дээд шүүх хянан хэлэлцэнэ.

ХБНГУ-н Эрүүгийн процессын хуулийн 337 дугаар зүйл:

1. Хууль зөрчсөн үндэслэлээр давж заалдах гомдол гаргахдаа тухайн шийдвэр нь зөвхөн хуулийн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд гаргана;

2. Эрх зүйн хэм хэмжээг алдаатай хэрэглэсэн, буруу хэм хэмжээ хэрэглэсэн нь хууль хэрэглээний алдаанд тооцогдох бөгөөд эдгээрийг давж заалдах харьцангуй үндэслэлүүд гэнэ.

Мөн хуулийн 338 дугаар зүйлд абсолют үндэслэлүүдийг заасан ба доорх үндэслэл тогтоогдвол давж заалдах журмаар хэргийг хянан хэлэлцэнэ. Үүнд:

- Шүүх хуралдаан нээх үед шүүх бүрэлдэхүүнийг танилцуулаагүй;
- Хуулиар хориглолт тогтоосон буюу татгалзан гаргах үндэслэл бүрдсэн шүүгч, мэргэжлийн бус шүүгч шийдвэр гаргахад оролцсон;
- Тухайн шүүгчийн ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой хүсэлтийг хянан шийдвэрлээгүй байхад шийдвэр гаргахад оролцсон;
- Шүүхийн харьяаллыг зөрчсөн;
- Прокурор болон шүүхийн хэлэлцүүлэгт оролцохыг хуулиар тогтоосон бусад этгээдүүдийг эзгүйд шүүх хуралдаан явуулсан;
- Шүүх хуралдаан нээлттэй байх зарчмыг зөрчсөн;
- Шүүхийн шийдвэрийг бичгээр гаргах, түүний хуульд заасан хугацааг хэтрүүлсэн;
- Шүүхийн шийдвэрт ач холбогдолтой асуултад хариулах яллагдагчийн эрхийг шүүх үндэслэлгүйгээр хязгаарласан гэх мэт.

Давж заалдах шүүх өмнөх шатны шүүхийн шийдвэрийг ХБНГУ-ын Эрүүгийн процесс хуулийн 352 дугаар зүйлд зааснаар зөвхөн гомдолд дурдагдсан асуудал болон үйл баримтын хүрээнд хянан хэлэлцэнэ. ХБНГУ-ын Эрүүгийн эрх зүйн судлаач Майкл Бонландерын тайлбарлаж буйгаар гомдол гаргагчаас дэвшүүлсэн үйл баримт нь гомдолд тусгагдсан тухайн нэг процессын зөрчилтэй хамааралгүй бөгөөд гомдолд дурдагдаагүй бусад зөрчлийг илэрхийлж байвал шүүхээс сүүлд илэрсэн зөрчлийн хүрээнд шийдвэр гаргаж болно.⁶ Гомдол гаргагч процессын хууль хэрэглээний талаар гомдол гаргахад ямар хэм хэмжээг, хэрхэн зөрчсөн үйл

⁵ Micheal Bohnlander, Principles of German Criminal Procedure, US, 2012, p.251, <https://b-ok.asia/book/3656000/4e3da3>, (Сүүлд үзсэн:2022.10.14).

⁶ Micheal Bohnlander, Principles of German Criminal Procedure, US., 2012, p.255, <https://b-ok.asia/book/3656000/4e3da3>, (Сүүлд үзсэн:2022.10.14).

баримтын талаар тодорхой бичиж ирүүлэх бол материаллаг эрх зүйн зөрчлийн хувьд заавал нарийн тодорхойлж гомдолд тусгасан байхыг шаарддаггүй байна.

ХБНГУ-ын Эрүүгийн процесс хуулийн 353, 354 дүгээр зүйлүүдэд *Revision* давж заалдах ажиллагаа явуулсны үр дүнд гаргах шүүхийн шийдвэрийн төрлүүдийг хуульчилсан байна. Үүнд:

- Давж заалдах гомдлыг үндэслэл бүхий гэж дүгнэж доод шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох;
- Хэргийн үйл баримтын талаар цааш шалгах шаардлагагүй буюу шүүх зөвхөн хууль хэрэглээний алдаа гаргасан бол түүнийг залруулах;
- Мөн шүүх гэмт хэргийн хууль зүйн үр дагаврыг буруу үнэлж тогтоосон, хэд хэдэн шийдвэрээр ял оногдуулахдаа ялыг буруу нэмж нэгтгэснээс бусад тохиолдолд шийдвэрийг доод шатны шүүхэд буцаана. Тухайлбал, хууль хэрэглээний алдааг залруулахад шаардлагатай хэргийн үйл баримт хангалттай тодорхой биш байвал хэргийг доод шатны шүүхэд буцаана.

(3) Хэрэг маргаан хянан шийдвэрлэхтэй холбоогүй бусад шүүхийн шийдвэр, захирамж, тогтоолын эсрэг гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг “*Beschwerde*” гэнэ. Тус улсын хууль тогтоомжуудад шүүхийн шатнаас эрүүгийн хэргийг прокурорт буцаах зохицуулалт тусгагдаагүй байна.

ХБНГУ-ын эрүүгийн шүүхийн тогтолцоо нь орон нутгийн шүүх (*Amtsgericht/Country court*), мужийн шүүх (*Landgericht/Regional Court*), мужийн дээд шүүх (*Oberlandesgericht/High regional court*), холбооны дээд шүүх (*Bundesgerichtshof/Federal Court of Justice*)-ээс бүрддэг. Орон нутгийн шүүх хөнгөн гэмт хэргүүдийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэнэ. Шүүхийн тухай хуулийн 73 дугаар зүйлд зааснаар мужийн шүүх хуулиар харьяалуулсан хүнд хэргүүдийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхээс гадна, орон нутгийн шүүхээс тогтоосон хэргийн үйл баримтыг эсэргүүцэж бичсэн давж заалдах гомдлыг хянах эрхтэй. Мужийн дээд шүүх мөн адил хуулиар харьяалуулсан хэргүүдийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх ба Шүүхийн тухай хуулийн 121 дүгээр зүйлд зааснаар дараах төрлийн давж заалдах гомдлуудыг хүлээн авч шийдвэрлэнэ. Үүнд:

- Орон нутгийн шүүхийн шийдвэрийг эсрэг “*Berufung*” давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэсэн мужийн шүүхийн шийдвэрт хяналт тавих;
- Мужийн шүүхийн шийдвэрийн эсрэг “*Revision*” төрлөөр гаргасан давж заалдах гомдлыг хянан шийдвэрлэх;
- Холбооны дээд шүүхээс бусад эрүүгийн хэргийн шүүхүүдийн хэрэг маргаан хянан шийдвэрлэхтэй холбоогүй бусад шийдвэр, захирамж, тогтоолуудын эсрэг гаргасан “*Beschwerde*” гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэх;
- Ял биелүүлэх ажиллагаатай холбоотой гаргасан шүүхийн шийдвэрийн эсрэг гомдлыг хянан шийдвэрлэх зэрэг.

Холбооны дээд шүүхийн хувьд Шүүхийн тухай хуулийн 135 дугаар зүйлд зааснаар мужийн шүүх, мужийн дээд шүүх хэргийг анхан шатны журмаар хянан

хэлэлцэж гаргасан шийдвэрийн эсрэг “*Revision*” давж заалдах гомдол болон мужийн дээд шүүхийн бусад шийдвэрүүдийн эсрэг гаргасан “*Beshwerde*” гомдлыг хянан шийдвэрлэнэ.

ХБНГУ-ын зохицуулалтын онцлог нь хамгийн доод шатны шүүхийн гаргасан хэргийн үйл баримттай холбоотой алдааг мужийн шүүхэд гурван шүүгчийн бүрэлдэхүүнтэй ганц л удаа хянах бөгөөд шүүхийн шат ахих тусам хууль хэрэглээний маргааныг хянан хэлэлцэх зүй тогтолтой. Хэргийн үйл баримтын талаар маргаж буй хэрэгт мужийн шүүх хяналт тавихдаа шинэ нотлох баримтуудыг шинжлэх, гэрчүүдийг дуудах, хэрэгт цугларсан нотлох баримтуудыг дахин шинжлэх замаар хэргийн нөхцөл байдлыг шинээр тогтоох, шийдвэр гаргах бүрэн эрхийг эдэлдэг. Хэргийг прокурорт буцаах тухай зохицуулалт байхгүй бөгөөд зөвхөн “*Revision*” төрлөөр давж заалдах ажиллагаа явуулах үед тухайн хэрэгт үйл баримтын болон хууль хэрэглээний алдаа аль аль нь илэрсэн тохиолдолд хэргийг доод шатны шүүх рүү буцааж болно.

2. Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын хувьд мөн адил холбооны улс боловч шүүхийн тогтолцоо нь ХБНГУ-аас зарим зүйлээр ялгаатай. Холбооны анхан (*district court*), давах (*appeal court*), хяналтын шатны (*Federal Supreme Court*) шүүхийн зэрэгцээ муж бүрд мужийн хуулийн дагуу гурван шатны шүүх үйл ажиллагаа явуулдаг.

Мужийн анхан шатны шүүхийн шийдвэрийг мужийн давж заалдах шатны шүүхэд хянаж, мужийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг мужийн дээд шүүх, түүний шийдвэрийг холбооны дээд шүүхэд хандан хянуулах боломжтой.

АНУ-ын 28 дугаар кодекс буюу Шүүхийн тухай хуулийн 2106 дугаар зүйлд:

“Дээд шүүх болон бусад давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий шүүхүүд хуулийн дагуу хянуулахаар ирүүлсэн шүүхийн шийдвэр, захирамж, тушаалуудыг баталгаажуулах, өөрчлөх, хүчингүй болгох, эсхүл тэдгээрийн зарим хэсгийг болон үндэслэлийг буцааж, тухайн нөхцөл байдалд нийцсэн нэмэлт ажиллагаа явуулахыг шаардаж болно” гэж заажээ.⁷

Талуудын зүгээс анхан шатны шүүх процесс зөрчсөн, хууль буруу хэрэглэсэн, буруу хуулийг хэрэглэсэн гэж үзэж буй тохиолдолд цааш давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй. Шүүгдэгчийг цагаатгасан хэрэгт прокурор давж заалдах гомдол гаргах эрхгүй байдаг. Энэ нь эрүүгийн эрх зүйн нэг гэмт хэрэгт нэг л удаа ял оногдуулах -“*double jeopardy*” зарчмын үүднээс прокурор нэг удаа яллахад ашигласан нотлох баримтуудаараа дахин шүүгдэгчийг яллах ёсгүй гэж үздэгтэй холбоотой байна.⁸ Харин шүүх хуралдааны өмнөх шатанд гарсан шийдвэр болон процесс зөрчил, нотлох баримтад тавигдах шаардлагыг зөрчсөнтэй холбоотой

⁷ Aaron-Andrew P. Bruhl, *The Remand Power and the Supreme Court’s Role, US.*, 2020 page 185-186, <https://scholarship.law.wm.edu/cgi/viewcontent.cgi?article=3065&context=facpubs>, (Сүүлд үзсэн: 2022.10.14).

⁸ Цахим эх сурвалж: <https://www.justia.com/criminal/procedure/criminal-appeals/>, (Сүүлд үзсэн: 2022.10.14).

асуудлаар давж заалдах боломж нээлттэй.⁹ Мөн гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрсөн шүүгдэгч дахин давж заалдах журмаар гомдол гаргах эрх эдэлдэггүй байна.

АНУ-д давж заалдах журмаар хэргийг хянан хэлэлцэж буй шүүхүүд шинэ нотлох баримт хүлээн авах байдлаар хэргийг дахин хянан шийдвэрлэх эрх хэмжээгүй буюу зөвхөн анхан шатны шүүх шударга процессоор дамжуулан хэргийг хянан шийдвэрлэсэн, хуулийг зөв хэрэглэсэн эсэхэд л хяналт тавина.¹⁰

Давж заалдах шатны шүүх *Appeal court* хүсэлтийг хүлээн авахдаа доод шатны шүүхийн гаргасан алдаа нь шүүхийн эцсийн шийдвэрт нөлөөлж байгаа эсэхийг хянаж үздэг ба эцсийн шийдвэрт нөлөөлөхөөргүй ялимгүй алдаа гарсан тохиолдолд шийдвэрийг хэвээр үлдээж давж заалдах гомдлыг хүлээж авдаггүй. Давж заалдах шатны шүүх хэргийг хянан хэлэлцээд дараах тохиолдлуудад доод шатны шүүхэд буцаана. Үүнд:

- Нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах;
- Өмнөх шийдвэрт гарсан зөрчилдөөний улмаас хэргийг дахин хэлэлцүүлэх нь зүйтэй гэж шүүх шийдсэн гэх мэт.¹¹

Холбооны дээд шүүхийн хувьд эрх зүйн зарчмын чухал асуудлыг хөндсөн, эсхүл хоёр түүнээс олон холбооны давж заалдах шатны шүүх хуулийг өөрөөр тайлбарлан хэрэглэсэн тохиолдолд нь доод шатны шүүхийн шийдвэрийг хүлээн авч хянана.¹²

Судалгааны явцад шүүхийн шатнаас хэргийг прокурорт буцаах асуудлаарх тохирох зохицуулалтыг олж чадсангүй. Гэсэн хэдий ч АНУ-ын шүүхийн тогтолцоо нь “*adversarial*” тогтолцоонд суурилдаг буюу хэргийн бодит үнэнийг тогтоох ажиллагаанд шүүгч гол үүргийг гүйцэтгэдэг. Прокурор яллах талын гэрч, нотлох баримтуудыг шүүх хуралдааны үеэр танилцуулах, өмгөөлөх талтай харилцан тэгш эрхийн үндсэн дээр мэтгэлцэх боловч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “*inquisitorial*” тогтолцоотой орнуудын адил идэвхтэй байр суурьтай оролцдоггүйтэй холбоотой байж болох юм гэж судлаачдын багийн зүгээс үзлээ.

3.Бүгд Найрамдах Хятад Ард Улс

БНХАУ-ын Үндсэн хууль¹³, Ардын шүүх байгуулах хуулийн 12 дугаар зүйлд зааснаар улсын шүүх тогтолцоо нь Ардын дээд шүүх, Газрын шат шатны ардын

⁹ Цахим эх сурвалж: <https://www.justia.com/criminal/procedure/criminal-appeals/>, (Сүүлд үзсэн:2022.10.17).

¹⁰ Цахим эх сурвалж: <https://www.uscourts.gov/about-federal-courts/court-role-and-structure/about-us-courts-appeals>, (Сүүлд үзсэн:2022.10.17).

¹¹ Цахим эх сурвалж: <https://www.uscourts.gov/statistics-reports/appellate-courts-and-cases-journalists-guide>, (Сүүлд үзсэн:2022.10.17).

¹² Цахим эх сурвалж: <https://www.uscourts.gov/about-federal-courts/types-cases/appeals>, (Сүүлд үзсэн:2022.10.17).

¹³ БНХАУ-ын Үндсэн хуулийн 129 дүгээр зүйл (中华人民共和国宪法), <http://jspgh.com/djwh/detail.aspx?id=4116>, (Сүүлд үзсэн:2022.10.17).

шүүх, Цэргийн шүүх зэрэг тусгай шүүхээс бүрдэх¹⁴ бөгөөд Ардын дээд шүүх нь газар бүрийн шат шатны ардын шүүх, тусгай ардын шүүхийн шүүн таслах ажлыг хянана. Өөрөөр хэлбэл Дээд шатны шүүх нь доод шатны шүүхийн шүүн таслах ажлыг хянах¹⁵ буюу газрын шат шатны ардын шүүх нь дээд шатны шүүх, дунд шатны шүүх, үндсэн шатны шүүхэд тус тус хуваагдана.¹⁶

Харин Тусгай ардын шүүхийн бүтцэд Цэргийн хэргийн шүүх, Далайн хэргийн шүүх, Санхүүгийн шүүх, Оюуны өмчийн шүүх /цахим шүүх/ багтана гэж хуульчилжээ.¹⁷

Ардын дээд шүүхийн эрх хэмжээг мөн хуулийн 6 дугаар зүйлд дараах хэргийг хянахаар тусгажээ. Үүнд:¹⁸

1. Хуульд зааснаар харьяалуулсан болон өөрийн харьяалалд хамаарах үндэслэлтэй гэж үзсэн хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;
2. Дээд шатны ардын шүүхийн шийдвэр, тогтоолд гаргасан гомдол, эсэргүүцэл;
3. Бүх Хятадын ардын төлөөлөгчдийн их хурлын байнгын хорооны дүрмийн дагуу гаргасан гомдол, эсэргүүцэл;
4. Шүүх хуралдаанд хяналт тавих журамд заасан дахин хэлэлцүүлэх хэрэг;
5. Дээд шатны ардын шүүхээс хянан зөвшөөрүүлэх хүсэлт гаргасан цаазаар авах ялаар шийтгэх хэрэг.

Харин давж заалдах шатны шүүх буюу хоёрдугаар шатны шүүхийн эрх хэмжээг Эрүүгийн процессын хуульд “давж заалдах шатны ардын шүүх давж заалдах гомдол, эсэргүүцлийн хүрээнд хязгаарлагдахгүй анхан шатны шийдвэрээр тогтоосон бодит байдал, хуулийн хэрэглээг бүхэлд нь хянана. Бүлэглэн гүйцэтгэсэн гэмт хэргийн зөвхөн хэсэг шүүгдэгч давж заалдсан бол хэргийг бүхэлд нь хянаж нэгтгэж шийдвэрлэнэ” гэж хуульчилжээ.¹⁹

Давж заалдах шатны ардын шүүх дараах хэргийг бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэнэ:²⁰

1. Шүүгдэгч, хохирогч болон түүний хууль ёсны төлөөлөгч анхан шатны тогтоосон бодит байдал, нотлох баримтад эсэргүүцэл гаргасан нь гэм бурууг тогтоох, ялын хэмжээг оногдуулахад нөлөөлөхүйц давж заалдах хэрэг;
2. Шүүгдэгч цаазаар авах ял шийтгүүлсэн давж заалдах хэрэг;
3. Ардын прокурорын газрын эсэргүүцэл гаргасан хэрэг;

¹⁴ БНХАУ-ын Ардын шүүх байгуулах хууль (中华人民共和国人民法院组织法), http://www.gov.cn/xinwen/2018-10/27/content_5334895.htm, (Сүүлд үзсэн:2022.10.17).

¹⁵ Мөн тэнд, 10 дугаар зүйл.

¹⁶ Мөн тэнд, 13 дугаар зүйл.

¹⁷ Мөн тэнд, 15 дугаар зүйл.

¹⁸ Мөн тэнд.

¹⁹ БНХАУ-ын Эрүүгийн процессын хуулийн 233 дугаар зүйл (中华人民共和国刑事诉讼法), <http://www.npc.gov.cn/npc/c12435/201811/59b0fd9941804636b9e403d17d6e3ebf.shtml>, (Сүүлд үзсэн:2022.10.17).

²⁰ Мөн тэнд, 234 дүгээр зүйл.

4. Бусад зайлшгүй шүүхээр хянан шийдвэрлэх хэрэг.

Анхан шатны ардын шүүх хэрэг хянан шийдвэрлэхдээ хуульд заасан процессыг зөрчсөн дараах нөхцөл байдлын аль нэгийг давж заалдах шатны ардын шүүх илрүүлсэн бол шийдвэрийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр тухайн шатны ардын шүүхэд буцаана.²¹

1. Энэ хуульд шүүх хуралдааныг нээлттэй явуулахад холбогдох заалтыг зөрчсөн;
2. Татгалзан гаргах журмыг зөрчсөн;
3. Хэргийг оролцогчдын хууль ёсны заалдах эрхийг хязгаарласан эсхүл хассан нь шударгаар шүүхэд нөлөөлсөн байж болзошгүй;
4. Шүүх бүрэлдэхүүн хууль бус байсан;
5. Хуульд заасан бусад процессыг зөрчсөн нь шударгаар шүүхэд нөлөөлсөн.

Давж заалдах шатны ардын шүүхээс анхан шатны шүүхийн тогтоолд гаргасан гомдол, эсэргүүцлийг дээр дурдсан үндэслэлийн дагуу хянаж гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгох эсхүл тогтоолыг хэрэгсэхгүй болгох, өөрчлөлт оруулах эрхтэй байна.²²

Харин Давж заалдах шатны ардын шүүхэд шүүгдэгч эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, ойр дотны хүнээс гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхдээ шүүгдэгчийн ялыг хүндрүүлэхгүй түүнчлэн, давж заалдах шатны ардын шүүх тухайн шатны ардын шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэрэгт ардын прокурорын газраас нэмж шинэ гэмт хэрэг үйлдсэн бодит байдлыг заалдсанаас бусад тохиолдолд тухайн шатны ардын шүүх шүүгдэгчийн ялыг мөн хүндрүүлэхгүй байхаар хуульчилжээ.²³

Давж заалдах шатны ардын шүүхээс анхан шатны шийдвэрт гаргасан гомдол, эсэргүүцлийг хянан шийдвэрлэхдээ дараах байдлын дагуу ялгаатай шийднэ:²⁴

1. Анхан шатны шийдвэрээр тогтоосон хэргийн бодит байдал болон хууль хэрэглээ оновчтой, ял шийтгэл тохирсон бол гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож, анхан шатны шийдвэрийг хэвээр үлдээнэ;
2. Анхан шатны шийдвэрээр тогтоосон бодит байдал нийцсэн боловч хууль хэрэглээ алдаатай эсхүл ял шийтгэл тохиромжгүй бол шийдвэрийг өөрчлөх;
3. Анхан шатны шийдвэрийн бодит байдал тодорхой биш эсхүл нотлох баримт хангалтгүй бол бодит байдлыг тодруулж шийдвэрийг өөрчлөх мөн анхан шатны шийдвэрийг хүчингүй болгож тухайн шатны ардын шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаана.

БНХАУ-д давж заалдах шатанд буюу хоёрдугаар шатны шүүх болон Ардын дээд шатны шүүхийн шийдвэр, тогтоол нь тухайн эрүүгийн хэргийн хувьд эцсийн

²¹ Мөн тэнд, 238 дугаар зүйл.

²² Мөн тэнд, 240 дүгээр зүйл.

²³ Мөн тэнд, 236 дугаар зүйл.

²⁴ Мөн тэнд, 236 дугаар зүйл.

хүчин төгөлдөр шийдвэр байх бөгөөд цаазаар авах ялаар шийтгэсэн хэргийг Ардын дээд шүүхээр заавал баталгаажуулах хүсэлт гаргадаг байна.

Давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээ нь анхан шатны шүүхийн шийдвэрээр тогтоосон бодит байдал, хууль хэрэглээ, процессын алдааг хянах эрхтэй байх бөгөөд ийнхүү хянахдаа гомдол, эсэргүүцлийн хүрээнд хязгаарлахгүй тухайн хэргийн шийдвэрийг бүрэн хянахаар тусгасан байна.

Дахин хэлэлцүүлэхээр буцаасан хэрэгт ардын прокурорын газар нэмж шинэ гэмт хэргийн талаар тусгаснаас бусад тохиолдолд өмнөх шатны шүүхийн шийдвэрээр оногдуулсан ялыг хүндрүүлэн зүйлчлэх эрхгүй байна. Давж заалдах журмаар хянан хэлэлцэх явцад анхан шатны шүүхийн шийдвэрт процессын алдаа гарсныг илрүүлбэл заавал тус шүүхэд буцаан дахин хэлэлцүүлэхээр хуульчилсан бол бодит байдлыг тодруулж шийдвэрийг өөрчлөх, хууль хэрэглээний алдааг давж заалдах шатанд залруулах эрхтэй байна.

Анхан шатны ардын шүүх прокуророос шилжүүлсэн эрүүгийн хэргийг хянаж тус шүүхийн харьяалалд хамаарахгүй, нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийлгэх шаардлагатай зэрэг тохиолдолд буцаах эрхийг Ардын дээд шүүхийн тайлбар²⁵-аар нарийвчлан зохицуулсан байна. Харин Эрүүгийн процессын хуульд шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцэж байхад хэргийн прокурорт буцаах боломжгүй бөгөөд харин прокурор шүүх хуралдааны явцад тухайн хэрэгт нэмэлт мөрдөн шалгах ажиллагаа хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд шүүх хуралдааныг нэг сар хүртэл хугацаагаар хойшлуулахаар хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, шүүх хэргийг прокурорт буцаах эрхгүй байх бөгөөд прокурорын саналаар шүүх хуралдааныг хойшлуулах эрхтэй байна.

4.Бүгд Найрамдах Солонгос Улс

БНСУ-ын эрүүгийн процессын ажиллагааны хуулийн 329 дүгээр зүйлд шүүхийн шатанд яллах ажиллагаа хүчингүй болсон бол зөвхөн шинээр илэрсэн эд мөрийн баримтад үндэслэн процессын ажиллагааг дахин явуулж болохоор зохицуулсан бөгөөд өөрөөр прокурор хэргийг дахин авч үзэж процессын ажиллагаа явуулах зохицуулалт байхгүй байна.

Мөн хуулийн 366 дугаар зүйлд хэргийг давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүх рүү буцаах зохицуулалтыг тусгажээ. Ингэхдээ улсын яллагч яллахаас татгалзсан болон шүүхийн харьяаллын бус үндэслэлээр шийдвэрийг хүчингүй болгож хэргийг анхан шатны шүүхэд буцаахаар зохицуулжээ. Хяналтын шатны шүүхэд яллах ажиллагаа хүчингүй болсон, харьяаллын бус үндэслэлээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож буцаахаар зохицуулжээ²⁶.

5.Бүгд Найрамдах Латви Улс

²⁵ Эрүүгийн процессын хуулийг хэрэглэх талаар Ардын дээд шүүхийн тайлбар (最高人民法院关于适用《中华人民共和国刑事诉讼法》的解释),

http://www.hefeiss.jcy.gov.cn/jcyw1/xsjc/202102/t20210204_3124003.shtml.

²⁶ БНСУ-ын эрүүгийн процессын хууль. 2021 он.

Латви улсын Эрүүгийн процессын хуулийн 403 дугаар зүйлд шүүхийн өмнөх шатанд прокурор тухайн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тодорхойлж чадахгүй бол тодорхой мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлагатай байгааг харуулж, шийдвэрээ татан авч, эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэхээр мөрдөн шалгах байгууллагад буцаахаар тусгажээ.

Хэргийг шүүхэд шилжүүлэх шатанд мөн хуулийн 486 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хэргийг хүлээн авсан шүүх хэргийн харьяалал, яллах шийдвэр нь байгаа эсэх, яллагдагчид нэг хувийг гардуулж өгсөн эсэх, хэргийн материалтай танилцсан эсэх асуудлуудыг тодруулна. Харьяаллын бус бол хэргийг зохих шүүхэд нь шилжүүлж, бусад тохиолдолд алдааг арилгуулахаар дээд шатны прокурорт хэргийг шилжүүлэн өгдөг.

Шүүх хуралдааны шатанд Эрүүгийн процессын хуульд прокурор шүүгдэгчид урьд сонгосон ялыг багасгаж, эсхүл нэмэгдүүлж өөрчлөх шаардлагатай бол энэ үндэслэлээ танилцуулж ялыг өөрчлөх үүргийг хуульчилсан. Үүний хүрээнд “шүүх хуралдааны явцад хэргийн өөр нөхцөл байдал тогтоогдож, зүйлчлэлийг хүндрүүлэн өөрчлөх шаардлагатай бол прокурорын хүсэлтээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нэмж явуулахаар шүүх хуралдааныг завсарлуулах ба энэ хугацаа нэг сараас илүү байж болохгүй” гэж прокурорын хүсэлтээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нэмж явуулах зорилгоор шүүх хуралдааныг түр завсарлах зохицуулалтыг бий болгожээ.

БНЛУ-д шүүхийн шатнаас хэргийг прокурорт буцаах тухай ойлголтыг бүр мөсөн хасаж, шүүхийн шатанд хэрэгт ач холбогдолтой нөхцөл байдлыг тодруулах шаардлага үүсэхэд шүүхийн мөрдлөг буюу “*court investigation*” явуулж ач холбогдол бүхий нөхцөл байдлыг шүүх өөрөө тодруулахын тулд түр маягаар мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг.

Эрүүгийн процесс хуулийн 563 дугаар зүйлд давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж шийдвэрлэх хоёр төрлийг тусгасан байна.

- Анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгож, эрүүгийн хэргийг анхан шатны шүүхэд дахин хянан хэлэлцүүлэхээр шилжүүлэх;
- Гэмт хэргийн улмаас олсон эд хөрөнгө, байцаан шийтгэх ажиллагааны зардал, эд мөрийн баримтыг хураах, нөхөн төлүүлэх, нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийн шаардлагыг хангасан анхан шатны шүүхийн шийдвэрийн зарим хэсгийг хүчингүй болгож, энэ хэсэгт шинээр шийдвэр гаргах, эсхүл хэргийг анхан шатны шүүхэд шилжүүлэх.

Хяналтын шатны шүүхийн тухайд мөн хуулийн 587 дугаар зүйлд зааснаар эрүүгийн хэргийг хянан хэлэлцээд дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргана. Үүнд:

- шийдвэрийг хэвээр үлдээх, хяналтын шатны гомдол, эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгох;

- шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр шилжүүлэх;
- шийдвэрийг бүхэлд нь буюу хэсэгчлэн хүчингүй болгож, эрүүгийн процессын ажиллагааг дуусгавар болгох;
- шийдвэрт өөрчлөлт оруулах;
- хяналтын шатны шүүх хуралдааныг дуусгавар болгох.
- Хяналтын шатны шүүх энэ хуулийн ноцтой зөрчлийг давж заалдах шатны шүүх арилгах боломжгүй гэж үзвэл хоёр шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхэд шинээр хэлэлцүүлэхээр шилжүүлнэ²⁷.

Дээрхээс үзэхэд БНЛУ-д хяналтын шатны шүүхээс хэргийг прокурорт буцаах шийдвэр гаргах боломжгүй байна.

6. Оросын Холбооны Улс

(1) ОХУ-д шүүх хуралдаанаас хэргийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэгт буцааж болдог. Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах үндэслэлд эрүүгийн хэргийг прокурорт буцаах нөхцөлүүд хамаарна.²⁸ Эрүүгийн процессын хуулийн 237 дугаар зүйлд шүүх өөрийн санаачилгаар болон талуудын хүсэлтээр эрүүгийн хэргийг прокурорт буцаах үндэслэлүүдийг хуульчилсан байна. Дараах үндэслэлүүдийн аль нэг бүрдсэн тохиолдолд шүүх өөрийн санаачилгаар эсхүл талуудын хүсэлтээр хэргийг прокурорт буцаана. Үүнд:

- Яллах дүгнэлт, яллах акт эсвэл яллах тогтоол энэ хуульд заасан шаардлагыг зөрчиж үйлдэгдсэн нь шүүгчийг тус яллах дүгнэлт, актыг эсвэл тогтоолыг үндэслэж тогтоол болон өөр шийдвэр гаргах боломжгүй болгосон;
- Хэрвээ шүүх энэ хуульд заасны дагуу гаргасан прокурорын шийдвэрийг хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий гэж үзсэн тохиолдлоос бусад үед яллах дүгнэлтийн, яллах актын эсвэл яллах тогтоолын хуулбарыг гэмт хэрэгт буруутгагдаж буй этгээдэд гардуулаагүй;
- Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай тогтоолтой хамт шүүхэд шилжүүлсэн эрүүгийн хэрэгт яллах дүгнэлт эсвэл яллах акт үйлдэх шаардлагатай бол;
- Энэ хуулийн 239.2-т зааснаас бусад, энэ хуулийн 153 дугаар зүйлд заасан эрүүгийн хэргүүдийг нэгтгэх үндэслэл байгаа тохиолдолд;
- Гэмт хэрэгт буруутгагдаж буй этгээд эрүүгийн хэргийн материалтай танилцахаас өмнө түүнд энэ хуулийн 217 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан эрхийг тайлбарлаагүй;

²⁷ Criminal Procedure law of Republic of Latvia (Эрүүгийн процессын хууль), 2005, <https://likumi.lv/ta/en/en/id/107820-criminal-procedure-law>, (Сүүлд үзсэн: 2022.10.17).

²⁸ "Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ/(Оросын Холбооны Улсын 2001 оны 12 дугаар сарын 18-ны №174 "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль") 229 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 дахь заалт http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/, (Сүүлд үзсэн: 2022.10.17).

- Яллах дүгнэлтэд, яллах актад, яллах тогтоолд, нийгэмд аюултай хүндэвтэр гэмт хэрэгт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж буй, гэмт хэрэгт буруутгагдаж буй этгээдийн үйлдлийг дахин зүйлчлэх үндэслэл байгааг илтгэх тухай тогтоолд тусгагдсан бодит нөхцөл байдал, эсхүл урьдчилсан хэлэлцүүлэг эсвэл шүүх хуралдааны явцад эдгээр этгээдүүдийн үйлдлийг илүү хүнд, нийгэмд аюултай гэмт хэрэг гэж зүйлчлэх үндэслэл байгааг харуулсан бодит нөхцөл байдал тогтоогдсон.²⁹
- Хялбаршуулсан хэлбэрээр хэрэгт урьдчилсан байцаалт явуулсан тохиолдолд шүүгч талуудын (хэргийн оролцогчдын) эсвэл өөрийн санаачилгаар ерөнхий журмаар хэрэг бүртгэлт явуулахаар эрүүгийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэхээр прокурорт буцаана.

Харин дараах үндэслэлүүдээр зөвхөн талууд хүсэлт гаргасан тохиолдолд хэргийг прокурорт буцаана. Үүнд:

- эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсний дараа гэмт хэрэгт буруутгагдаж буй этгээдийг буруутгасан үйлдлийн шинэ нийгэмд аюултай үр дагавар гарсан нь түүнийг хүнд гэмт хэрэгт буруутгах үндэслэл болсон;
- өмнө нь гаргасан шүүхийн шийтгэх шийдвэрийг энэ хуулийн 49 дүгээр бүлэгт заасны дагуу хүчингүй болгосон, тэдгээрийг хүчингүй болгох үндэслэл болсон шинээр эсвэл дахин илэрсэн нөхцөл байдал нь гэмт хэрэгт буруутгагдаж буй этгээдийг илүү хүнд гэмт хэрэгт буруутгах гэх мэт.³⁰

(2) Давж заалдах болон хяналтын шатны шүүх эрүүгийн хэргийг прокурор болон доод шатны шүүхэд буцаах эрх хэмжээ эдэлдэг. Тодруулбал, **нэгдүгээр давж заалдах шатны шүүхээс** эрүүгийн хэргийг хянан хэлэлцээд дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргаж болно. Үүнд:³¹

- Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож эрүүгийн хэргийг шүүх хурал эсвэл шүүх хуралдаанд бэлтгэх үе шатнаас эхлэн шинэ шүүх хуралдаанд хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд шилжүүлэх (буцаах);
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан эрүүгийн хэргийг прокурорт буцаах нөхцөл байдал үүссэн тохиолдолд анхан

²⁹ "Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ/(Оросын Холбооны Улсын 2001 оны 12 дугаар сарын 18-ны №174 "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль") 237 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 1.1 дахь заалт http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/, (Сүүлд үзсэн: 2022.10.17).

³⁰ "Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ/(Оросын Холбооны Улсын 2001 оны 12 дугаар сарын 18-ны №174 "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль") 237 дугаар зүйлийн 1.2 дахь заалт, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/, (Сүүлд үзсэн: 2022.10.17).

³¹ "Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ/(Оросын Холбооны Улсын 2001 оны 12 дугаар сарын 18-ны №174 "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль"), 389.20 дугаар зүйл, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/, (Сүүлд үзсэн: 2022.10.17).

шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг прокурорт буцаах тухай шийдвэр гаргах;

- Шүүхийн шийтгэх тогтоолыг эсвэл маргаан бүхий шүүхийн шийдвэрийг өөрчлөх гэх мэт.

Анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх явцад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон эрүүгийн хуулийг зөрчсөнийг нэгдүгээр давж заалдах шатны шүүхээр зөвтгөх боломжгүй бол өмнөх шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг шинэ шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд, эсхүл прокурорт буцаах шийдвэр гаргадаг байна.³²

Хоёрдугаар давж заалдах шатны шүүхээс эрүүгийн хэргийг хянан хэлэлцээд эл асуудлаар дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргаж болно. Үүнд:

- Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, түүнээс хойших бүх шүүхийн шийдвэрүүдийг хүчингүй болгож, эрүүгийн хэргийг шинэ шүүх хуралдаанд хэлэлцүүлэхээр шилжүүлэх эсхүл прокурорт буцаах.
- Нэгдүгээр давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, эрүүгийн хэргийг шинэ шүүх хуралдаанд хэлэлцүүлэхээр нэгдүгээр давж заалдах шатны шүүхэд шилжүүлэх (буцаах);
- Хоёрдугаар давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, эрүүгийн хэргийг шинэ шүүх хуралдаанд хэлэлцүүлэхээр хоёрдугаар давж заалдах шатны шүүхэд шилжүүлэх (буцаах);
- Хоёрдугаар давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох, хэвээр нь үлдээх, эсвэл шийтгэх тогтоол, түүнээс хойших бүх шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;
- Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, эсвэл үүнээс хойших бүх шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж шийдвэрлэх боломжтой.

ОХУ-ын Эрүүгийн процессын хуулийн 401.15 дугаар зүйлд зааснаар хууль заасан хэргийг прокурорт буцаах нөхцөл бүрдвэл хоёрдугаар давж заалдах шатны шүүхээс өмнөх шатны шүүхийн шийдвэрүүдийг хүчингүй болгож прокурорт буцаах үндэслэл болно.

Харин **хяналтын шатны шүүх** эрүүгийн хэргийг хянан хэлэлцээд хэргийг доод шатны шүүх болон прокурорт буцаах талаар дараах шийдвэрүүдийг гаргах эрх хэмжээтэй. Үүнд:

- Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол болон түүнээс хойших бүх шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, эрүүгийн хэргийг шинэ шүүх хуралдаанд хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд шилжүүлэх (буцаах);
- Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, эрүүгийн хэргийг давж заалдах шатны шүүхэд шинэ шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шилжүүлэх (буцаах);³³

³² Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ/(Оросын Холбооны Улсын 2001 оны 12 дугаар сарын 18-ны №174 “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”), 389.22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/, (Сүүлд үзсэн: 2022.10.17).

³³ Мөн тэнд.

- Хоёрдугаар давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, эрүүгийн хэргийг хоёрдугаар давж заалдах шатны шүүхэд шинэ шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шилжүүлэх (буцаах);
- Хоёрдугаар давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэвээр нь үлдээх эсвэл шийтгэх тогтоол болон түүнээс хойших бүх шүүхийн шийдвэрийг өөрчлөх;
- Энэ хуулийн 389.22 дугаар зүйлийн гурав дахь хэсэгт³⁴ заасан үндэслэл байгаа тохиолдолд шийтгэх тогтоолыг, тодорхойлолтыг (магадлалыг), тогтоолыг болон түүнээс хойших бүх шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, эрүүгийн хэргийг прокурорт буцаана.
- Шүүхийн шийтгэх тогтоол, тодорхойлолт (магадлал) эсвэл тогтоолд болон түүнээс хойших бүх шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах зэрэг шийдвэрүүдийг гаргаж болохоор хуульчилжээ.

7.Бүгд Найрамдах Казакстан Улс

(1)БНКУ-ын Эрүүгийн процессын хуулийн 321 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хэргийг прокурорт буцаах нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах үндэслэлд мөн адил тооцогддог. Энэ зохицуулалтыг ОХУ-ын адилаар шүүх хуралдааны шатнаас хэргийг урьдчилсан хэлэлцүүлэгт буцаах боломж олгодог гэж үздэг байна.³⁵

Эрүүгийн процессын хуулийн 323 дугаар зүйлд “Үндсэн шүүх хуралдааныг товлох, шүүхийн өмнөх шатанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдавчилсан журмаар хянан шийдвэрлэх үед шүүх хуралдааныг явуулах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэлцлийг байгуулахад саад болж буй процессын хэм хэмжээний зөрчил илэрсэн тохиолдолд шүүх тэдгээрийг зөвтгөхөөр хэргийг прокурорт буцаана” хэмээн хэргийг прокурорт буцаах ерөнхий үндэслэлийг тогтоосон байна.

Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх явцад давж заалдах шатны шүүхэд л гагцхүү “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэлцлийг шүүхийн өмнөх шатанд эрүүгийн процессын хуулийг зөрчиж үйлдсэнтэй холбогдуулан шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг прокурорт буцаах” эрх хэмжээг олгосон байна. Хяналтын шатны шүүхэд хэргийг прокурорт буцаах эрх хэмжээ байхгүй.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэлцэлтэй холбогдуулан шүүхээс дараах нөхцөл байдлууд илэрвэл хэргийг прокурорт буцааж болно. Үүнд:

³⁴ Давж заалдах шатны журмаар эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх явцад энэ хуулийн 237 дугаар зүйлийн 1 дэх хэсэг мөн 1.2. дахь хэсгийн 1 дэх заалтад заасан нөхцөл байдлыг илрүүлсэн бол анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол эсвэл бусад шийдвэрийг эрүүгийн хэргийг прокурорт буцааснаар хүчингүй болгоно” Уголовно-процессуальный кодекс Российской Федерации” от 18.12.2001 N 174-ФЗ// (Оросын Холбооны Улсын 2001 оны 12 дугаар сарын 18-ны №174 “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”), 389.22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/, (Сүүлд үзсэн: 2022.10.17).

³⁵ Уголовно-процессуальный кодекс Республики Казахстан от 4 июля 2014 года № 231-V ЗРК// (Бүгд Найрамдах Казакстан Улсын 2014 оны 6 дугаар сарын 4-ний № 231 “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”), <https://adilet.zan.kz/rus/docs/K1400000231#z2843>, (Сүүлд үзсэн: 2022.10.17).

- Тохиролцох ажиллагааг явуулах үндэслэл байхгүй;
- Хэрвээ шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэлцэлд заасан хэргийн зүйлчлэл, иргэний нэхэмжлэлийн хэмжээтэй эсвэл ялын төрөл, хэмжээтэй санал нийлээгүй тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шинэ хэлцэл байгуулахаар эрүүгийн хэргийг прокурорт буцаах;
- Шүүгдэгчийн гэм буруугийн талаар шүүх эргэлзэж байвал, тохиролцох ажиллагааны журмаар хэргийг хянан хэлэлцэхээс татгалзах, эрүүгийн хэргийг прокурорт буцаах гэх мэт.

(2) Доод шатны шүүхэд эрүүгийн хэргийг буцаах тухайд:

Процессын хуулийн 431 дүгээр зүйлд зааснаар давж заалдах шатны шүүх дараах шийдвэрүүдийн аль нэгийг гаргах эрхтэй. Үүнд:³⁶

- Шийтгэх тогтоолыг өөрчлөх;
- Тангарагтны шүүгчдийн оролцоотойгоор шийдвэрлэсэн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг шинэ шүүх хуралдаанд хэлэлцүүлэхээр шилжүүлэх;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэлцлийг шүүхээс өмнөх ажиллагааны шатанд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг зөрчиж үйлдсэнтэй холбоотой энэ хуульд заасны дагуу шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг прокурорт шилжүүлэх (буцаах);
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэлцлийг процессын хуулийг зөрчиж боловсруулсантай холбогдуулан шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, эрүүгийн хэргийг шинээр шүүх хуралдаанд хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд шилжүүлэх (буцаах).
- Хэрвээ хэргийг бүхэлдээ хянан үзээгүй тохиолдолд шүүхийн тогтоолыг хүчингүй болгож, хэргийг шинэ шүүх хуралдаанд хэлэлцүүлэхээр шилжүүлэх зэрэг болно.

Мөн хуулийн 494 дүгээр зүйлд хяналтын шатны шүүх “анхан шатны шүүхэд тангарагтны шүүгчдийн оролцоотойгоор хэргийг хянан хэлэлцсэн, мөн энэ хуульд заасан процессын эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд шийтгэх тогтоолыг болон түүнээс хойших бүх тогтоолуудыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхээр шинэ шүүх хуралдаанд хянан хэлэлцүүлэхээр шилжүүлэх” эрхийг хуульчилжээ.³⁷

³⁶ Уголовно-процессуальный кодекс Республики Казахстан от 4 июля 2014 года № 231-V ЗРК// (Бүгд Найрамдах Казахстан Улсын 2014 оны 6 дугаар сарын 4-ний № 231 “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”), <https://adilet.zan.kz/rus/docs/K1400000231#z2843>, (Сүүлд үзсэн: 2022.10.17).

³⁷ Мөн тэнд.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнг удиртгал хэсэгт дэвшүүлсэн зорилгод тулгуурлан дараах дэд хүрээнүүдэд ангилан дүгнэв.

Шүүхийн шатнаас эрүүгийн хэргийг прокурорт буцаах боломжтой эсэх нь тухайн улс орны эрүүгийн процессын эрх зүйн онцлогтой уялдан харилцан адилгүй байна. АНУ, ХБНГУ, БНЛУ, БНКУ, БНХАУ-д шүүхийн шатнаас прокурорт хэргийг буцаах талаарх зохицуулалт байдаггүй. АНУ-ын хувьд шүүхийн “*adversarial*” тогтолцоонд суурилдаг. Өөрөөр хэлбэл, шүүх хуралдааны үеэр талуудын эрх тэгш мэтгэлцээнд үндэслэн хэргийн үнэн бодит байдлыг тогтооход шүүгч гол үүрэг гүйцэтгэдэгтэй холбоотойгоор хэргийн үйл баримтыг тодруулах зорилгоор прокурорт буцаах зохицуулалт хэрэглэх явдал байдаггүй байж болох юм гэж судлаачдын багийн зүгээс үзлээ. Харин ХБНГУ болон БНЛУ-уудад шүүх хуралдааны үеэр хэргийн үйл баримтыг тодруулах шаардлага гарсан тохиолдолд шүүх өөрөө мөрдөн шалгах ажиллагаа явуулах “*court investigation*” буюу шүүхийн мөрдлөг хэрэгслийг хэрэглэх боломжийг хуульчилсан байна. Жишээлбэл, БНЛУ-д “шүүх хуралдааны үеэр хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэн өөрчлөх нөхцөл байдал илэрвэл прокурорын хүсэлтээр нэмэлт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлага гарсан тохиолдолд шүүх хуралдааныг 1 сараас илүүгүй хугацаанд завсарлуулж болно”. БНХАУ-д үүнтэй төстэй боловч “шүүх хуралдааны үеэр хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт явуулах шаардлагатай гэж *прокурор үзвэл* шүүх хуралдааныг 1 сар хүртэлх хугацаагаар хойшлуулж болох” зохицуулалт үйлчилдэг. Өөрөөр хэлбэл, шүүхээс хэргийг прокурорт буцаахаар шийдвэрлэж болохгүй. Гэсэн хэдий ч хэрэв прокурор өөрөө шаардлагатай гэж үзвэл шүүх хуралдааныг тодорхой хугацаагаар хойшлуулж нэмэлт мөрдөн байцаалт явуулж болно. БНЛУ болон БНХАУ-д эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх шатанд хэргийг прокурорт буцаах нөхцөлийг ижил хуульчилсан. БНКУ-д шүүх хуралдааныг товлох, шүүхийн өмнөх шатанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хурдавчилсан журмаар хянан шийдвэрлэх үед шүүх хуралдааныг явуулах болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэлцлийг байгуулахад саад болж буй процессын хэм хэмжээний зөрчил илэрсэн тохиолдолд шүүхээс эрүүгийн хэргийг прокурорт буцаах бөгөөд давж заалдах шүүхээс голчлон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хэлцэл хууль зөрчсөнтэй холбоотой тохиолдлуудад хэргийг прокурорт буцаадаг. Тус улсад хяналтын шатны шүүхээс эрүүгийн хэргийг прокурорт буцаадаггүй.

ОХУ-д анхан, давах, хяналтын шатны шүүхүүд Эрүүгийн процессын хуульд заасан эрүүгийн хэргийг прокурорт буцаах үндэслэлүүдээс тогтоогдвол хэргийг прокурорт буцаах шийдвэр гаргах эрхтэй. БНСУ-ын тухайд хэргийн прокурорт буцаахад онцгой нөхцөл тавигддаг. Тодруулбал, шүүхийн шатанд яллах ажиллагаа хүчингүй болсон бол зөвхөн шинээр илэрсэн эд мөрийн баримтад үндэслэн процессын ажиллагааг дахин явуулж болохоор зохицуулсан.

Дээд шатны шүүхээс эрүүгийн хэргийг доод шатны шүүхэд буцаахад тухайн улсын давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий шүүхэд шинээр нотлох баримт шинжлэн судлах, хэргийн нөхцөл байдалд дүгнэлт хийх эрх олгогдсон эсэхээс хамаарч хоёр хэсэгт ангилж болохоор байна. Нэгдүгээрт, ХБНГУ-

д анхан шатны шүүхийн тогтоосон хэргийн үйл баримттай маргасан давж заалдах гомдлыг мужийн шүүх хянан хэлэлцэхдээ гэрчүүдийг дуудах, хэрэгт авагдсан нотлох баримтуудыг дахин хянан хэлэлцэх, шинэ нотлох баримт шинжлэх судлах замаар хэргийн үйл баримтад өөрийн дүгнэлтийг өгч өөрчлөн шийдвэрлэх боломжтой. Иймээс тус улсад доод шатны шүүхэд хэргийг буцаах зохицуулалт байдаггүй. Харин АНУ, ОХУ, БНСУ, БНЛУ, БНКУ, БНХАУ-д давж заалдах шүүхүүдэд ийм эрх хэмжээ байхгүй. Тухайлбал, АНУ-ын шүүхийн тухай хуульд зааснаар бүх шатны шүүх хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр доод шатны шүүхэд буцааж болно. ОХУ-д анхан шатны шүүхийн шийдвэрт гарсан алдааг давж заалдах шатны шүүх залруулах боломжгүй бол тухайн шүүхэд буцааж болно. БНСУ-д давж заалдах, хяналтын шатны шүүх улсын яллагч яллахаас татгалзсан болон шүүхийн харьяаллын бус үндэслэлээр доод шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг холбогдох шүүхэд буцааж болно. БНЛУ-д давж заалдах болон хяналтын шатны шүүх хэргийг доод шатны шүүхэд буцаах эрхтэй. Хяналтын шатны шүүх нь эрүүгийн процесс хуулийн ноцтой зөрчлийг давж заалдах шатны шүүх засварлах боломжгүй гэж үзвэл хэргийг анхан шатны шүүхэд буцаах эрхийг эдэлдэг байна. БНКУ-д “процессын хэм хэмжээ зөрчсөн” бол өмнөх шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож хэргийг шүүхэд буцаах үндэслэлийг давж заалдах болон хяналтын шатны шүүхэд аль алинд нь ижил хуульчилсан. БНХАУ-ын хувьд “анхан шатны шийдвэрийн бодит байдал тодорхой биш эсхүл нотлох баримт хангалтгүй бол бодит байдлыг тодруулж шийдвэрийг өөрчлөх мөн анхан шатны шийдвэрийг хүчингүй болгож тухайн шатны ардын шүүхэд дахин хэлэлцүүлэхээр буцаана”.

Гэхдээ ХБНГУ-д зарим онцгой тохиолдолд тодруулбал, хэргийн оролцогчдод шүүх бүрэлдэхүүнийг мэдэгдээгүй, ашиг сонирхлын зөрчилтэй шүүх бүрэлдэхүүнээр, эсхүл нээлттэй шүүхийн зарчмыг зөрчиж хэргийг хянан шийдвэрлэсэн бол доод шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр холбогдох шүүхэд буцааж болно. Энэ нь БНХАУ-ын зохицуулалттай нэлээд төстэй байна.

Судалсан орнуудын хүрээнд хяналтын шат, давж заалдах шатны шүүх өмнөх шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулж эцэслэн шийдвэрлэх эрх хэмжээ зөвхөн ХБНГУ-ын мужийн шүүхэд л байна.

Ерөнхийд нь авч үзвэл давж заалдах журмаар дээд шатны шүүхүүд доод шатны шүүхийн шийдвэрийг хянах харилцан адилгүй өөр өөрсдийн онцлогийг шингээсэн зохицуулалтуудыг хэрэглэж байна. Давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь доод шатны шүүхийн шийдвэрийн алдааг засах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилготой. Нөгөө талаас иргэний шударга шүүхээр шүүлгэх эрхийн баталгааг хангах ач холбогдолтой учраас дээд шатны шүүх доод шатны шүүхийн шийдвэрийг хянан хэлэлцээд зөвтгөх хуулийн гаргалгаа зайлшгүй байх нь зүй ёсны асуудал болж байна. Гэхдээ үүнийг эрүүгийн процессын эрх зүйн “*non double jeopardy*” буюу нэг хэрэгт хоёр ял шийтгэхгүй байх зарчимтай уялдуулан хамгийн оновчтой хувилбарыг боловсруулах нь чухал юм.

Цахим эх сурвалж:

- Micheal Bohnlander, Principles of German Criminal Procedure, US, 2012 URL:<https://b-ok.asia/book/3656000/4e3da3>;
- German Code of Criminal Procedure (ХБНГУ-ын Эрүүгийн процессын хууль), 1987 URL: [German Code of Criminal Procedure \(Strafprozeßordnung – StPO\) \(gesetze-im-internet.de\)](http://gesetze-im-internet.de);
- Aaron-Andrew P. Bruhl, The Remand Power and the Supreme Court's Role, US., 2020 URL: <https://scholarship.law.wm.edu/cgi/viewcontent.cgi?article=3065&context=facpubs>;
- БНХАУ-ын Үндсэн хууль (中华人民共和国宪) URL: <http://jspgh.com/djwh/detail.aspx?id=4116>;
- БНХАУ-ын Ардын шүүх байгуулах хууль (中华人民共和国人民法院组织法), URL: http://www.gov.cn/xinwen/2018-10/27/content_5334895.htm;
- ¹ БНХАУ-ын Эрүүгийн процессын хууль (中华人民共和国刑事诉讼法), URL:<http://www.npc.gov.cn/npc/c12435/201811/59b0fd9941804636b9e403d17d6e3ebf.shtml>
- Эрүүгийн процессын хуулийг хэрэглэх талаар Ардын дээд шүүхийн тайлбар (最高人民法院关于适用《中华人民共和国刑事诉讼法》的解释), URL: http://www.hefeiss.jcy.gov.cn/jcyw1/xsjc/202102/t20210204_3124003.shtml
- Criminal Procedure law of Republic of Latvia (Эрүүгийн процессын хууль), 2005 URL: <https://likumi.lv/ta/en/en/id/107820-criminal-procedure-lawd>;
- "Уголовно-процессуальный кодекс Российской Федерации" от 18.12.2001 N 174-ФЗ// (Оросын Холбооны Улсын 2001 оны 12 дугаар сарын 18-ны №174 “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”) URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_34481/;
- Уголовно-процессуальный кодекс Республики Казахстан от 4 июля 2014 года № 231-V ЗРК// (Бүгд Найрамдах Казахстан Улсын 2014 оны 6 дугаар сарын 4-ний № 231 “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”) URL: <https://adilet.zan.kz/rus/docs/K1400000231#z2843>
- Цахим эх сурвалж: <https://www.justia.com/criminal/procedure/criminal-appeals/>

Хавсралт

Хавсралт 1

